

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ОЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилго

1.1. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын ойн экосистемийн тэнцвэр, биологийн олон янз байдлыг хадгалах, ойн сан, түүний баялгийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

2 дугаар зүйл. Ойн тухай хууль тогтоомж

2.1. Ойн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “ой” гэж 5 метр болон түүнээс өндөр ургах боломжтой, 10-аас дээш хувийн титмийн бүрхэцтэй, 0.5 га-аас доошгүй талбайд зонхилон ургасан модлог ургамал, бут, сөөг, амьтан, бичил биет, хөрс, ус, агаарын харилцан үйлчлэл бүхий экосистемийг;

3.1.2. “ойн баялаг” гэж ойн модны нөөц, ойн дагалт баялаг болон экосистемийн үйлчилгээний нийлбэрийг;

3.1.3. “ойн экосистем” гэж байгалийн болон таримал ойд орших амьд болон амьгүй бүрэлдэхүүн, тэдгээрийн харилцан хамаарал, экологийн үйл явц, экосистемийн үйлчилгээний нийлбэрийг;

3.1.4. “заган ой” гэж говь, цөлийн бүсэд заг мод зонхилон ургасан, 0.3 га-аас доошгүй талбай, арваас дээш хувийн титмийн бүрхэц бүхий, хөрс хамгаалах, цөлжилтийг сааруулах ач холбогдолтой ойн экосистемийг;

3.1.5. “татмын ой” гэж гол мөрөн, нуур, булаг шанд, ус намгархаг газрын болон хиймэл нуур, хөв цөөрмийн татмын бүсэд ургасан ойг;

3.1.6. “ойн баялаг” гэж ойн модны нөөц, ойн дагалт баялаг болон экосистемийн үйлчилгээний нийлбэрийг;

3.1.7. “ойн модны нөөц” гэж ойн талбай болон модны эзлэхүүнээр илэрхийлсэн хэмжээг;

3.1.8. “ойн дагалт баялаг” гэж самар, жимс, жимсгэнэ, мөөг, эмийн ургамал, давирхай, шүүс болон ойгоос бэлтгэж ашиглаж болох бусад баялгийг;

3.1.9. “ойн аж ахуйн арга хэмжээ” гэж ойжуулах, ойг нөхөн сэргээх, ойн арчилгаа, эрүүл ахуйн цэвэрлэгээний огтлол хийх, ой зохион байгуулалт, ойн тооллогын судалгаа, ойн хөнөөлт организмын судалгаа хийх, тэмцэх үйл ажиллагааг;

3.1.10. “ойн цэвэрлэгээ” гэж ойн түймэр, хөнөөлт организмд нэрвэгдсэн, хөгширсөн, хүчтэй салхи, их цасанд өртсөний улмаас амьдрах чадваргүй болсон босоо хатсан болон унасан мод, гишүү, мөчрийг цэвэрлэх замаар ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг;

3.1.11. “ойн арчилгаа” гэж ойн бүтэц, чанарыг сайжруулах зорилгоор хийгдэх арга хэмжээг;

3.1.12. “ойжуулалт” гэж ой байгаагүй газарт ой шинээр бий болгох үйл ажиллагааг;

3.1.13. “ойн нөхөн сэргээлт” гэж доройтсон ойг сэргээх үйл ажиллагааг;

3.1.14. “ойн эдийн засаг” гэж ойг хамгаалах, нөхөн сэргээх, ашиглах, боловсруулах болон экосистемийн үйлчилгээг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбогдсон үйлдвэрлэл, үйлчилгээний тогтолцоог;

3.1.15. “ойн экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж ойн баялгийн нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээ болон экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг батлагдсан аргачлалд үндэслэн мөнгөн дүнгээр илэрхийлснийг;

3.1.16. “ойн нүүрстөрөгчийн шингээлт” гэж ойн экосистем нүүрстөрөгч шингээж, хуримтлуулах үйл явцыг;

3.1.17. “ойн нүүрстөрөгчийн ялгарал” гэж ойн экосистем доройтож, нүүрстөрөгч алдагдах үйл явцыг;

3.1.18. “ойн нүүрстөрөгчийн кредит” гэж хэмжиж бүртгэсэн нүүрстөрөгчийн шингээлт эсхүл ялгаруулахаас сэргийлсэн хэмжээг;

3.1.19. “мод” гэж 5 метрээс дээш өндөр ургах боломжтой, ганц голлосон иштэй олон наст модлог ургамлыг;

3.1.20. “сөөг” гэж 5 метрээс бага өндөртэй, олон салаалсан иштэй, олон наст модлог ургамлыг;

3.1.21. “хуш модны самрын биологийн ургац” гэж тухайн жилд хушин ойд ургасан самрын нийт ургацыг;

3.1.22. “ногоон байгууламж” гэж хот, суурин газрын орчинд байгаль орчин, нийгэм, гоо зүйн зориулалтаар байгуулсан модлог ургамал бүхий талбай, хотын ойг;

3.1.23. “таримал ой” гэж урьд өмнө нь ой байгаагүй газарт зориудаар модлог ургамал тарьж ургуулан бий болгосон ойг;

3.1.24. “нөхөрлөл” гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8-д заасны дагуу байгуулагдсан нөхөрлөлийг;

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Тусгай хамгаалалттай газар нутаг дахь ойн хамгаалалт, ашиглалтын дэглэмийг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар, тусгай хамгаалалттай газарт явуулах ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

4.2. Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхтэй холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Галын аюулгүй байдлын тухай болон Гамшгаас хамгаалах тухай хуулиар тус тус зохицуулна.

4.3. Энэ хуулиар зохицуулаагүй дараах харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна:

4.3.1. агро-ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.3.2. ойн баялгийн нөөцийг хүнсний зориулалтаар боловсруулах, худалдаалах;

4.3.3. ойн сан бүхий газар эзэмших, ашиглахаас бусад газартай холбоотой;

4.3.4. ойн салбарын мэргэжлийн холбоотой бусад.

4.4. Ой, мод, сөөгтэй холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулснаас бусад хот, суурин газрын цэцэрлэгжүүлэлт болон бусад ногоон байгууламжтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна.

4.5. Ойд ан агнахтай холбоотой харилцаанд энэ хууль үйлчлэхгүй.

5 дугаар зүйл. Төрөөс ойн талаар баримтлах зарчим

5.1. Төрөөс ойн талаар дараах зарчмыг баримтална:

5.1.1. Монгол Улсын ой төрийн хяналт, хамгаалалтад байх;

5.1.2. ойн баялгийн нөөцийг ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;

5.1.3. ойн баялгийн нөөцийг хуульд заасан нөхцөл, журмын дагуу зориулалтаар нь үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх;

5.1.4. ойн экосистемийн үйлчилгээ хүртээмжтэй байх, ойн эдийн засгийг дэмжих;

5.1.5. ойн менежментийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ОЙН БҮСИЙН АНГИЛАЛ, ДЭГЛЭМ

6 дугаар зүйл. Ойн сан бүхий газар

6.1. Ойн сан бүхий газарт ой, мод, сөөг бүхий газар, заг бүхий газар, ойн цоорхой, цагаан энгэр, доройтсон ойн талбай, ой тэлэн ургахад шаардлагатай талбай, ой доторх мод үржүүлгийн талбай, ойн нөхөн сэргээлт хийсэн талбай, ойн түймрээс хамгаалах зурвас, таримал ойн эзлэх талбай хамаарна.

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан ой тэлэн ургахад шаардлагатай талбайд ойн захаас 100 метр хүртэлх талбай болон таримал ой бий болгох зорилгоор газрын нэгдмэл сангийн ангилалд хамаарах ойн сан бүхий газар хамаарна.

6.3. Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эзэмшлийн газарт байгаа мод үржүүлгийн талбай нь ойн сан бүхий газарт хамаарахгүй.

6.4. Ойн сан бүхий газрыг хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хашаалах, ойд нэвтрэх эрхийг хязгаарлахыг хориглоно.

7 дугаар зүйл. Ойн бүсийн ангилал

7.1. Ойн экологи, нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг нь харгалзан ойн бүсийг дор дурдсанаар ангилна:

7.1.1. хамгаалалтын бүсийн ой;

7.1.2. ашиглалтын бүсийн ой;

7.1.3. тусгай зориулалтын ой.

7.2. Ойн тооллого, ой зохион байгуулалтын үр дүнг үндэслэн орон нутгийн иргэдийн саналыг харгалзан ойн ангиллыг тогтоох, өөрчлөх, ангилал хооронд шилжүүлэх асуудлыг ойн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.3. Төрийн захиргааны байгууллага нь ойн тооллого, ой зохион байгуулалтыг тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлнэ.

7.4. йн тооллого, ой зохион байгуулалтыг хийх аргачлалыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

8 дугаар зүйл. Ойн тооллого

8.1. Ойн тооллогыг улсын хэмжээнд арван жил тутам явуулна.

8.2. Ойн тооллогоор ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгарал, биологийн олон янз байдал, ховор болон нэн ховор зүйл, экосистемийн төлөв байдлыг тодорхойлно.

9 дүгээр зүйл. Ой зохион байгуулалт

9.1. Ой зохион байгуулалтын ажлыг бүсчлэн, арван жил тутам хийнэ.

9.2. Ойн зохион байгуулалтаар ойн талбай, ойн баялгийн нөөц, насны бүтэц, төрөл зүйлийн бүрэлдэхүүн, ойн төлөв байдал, экосистемийн даац, нөхөн сэргэх чадавх, доройтлын түвшин, хөрсний хэв шинж, түймэр, ойн хөнөөлт организмын учруулах эрсдэл, орон нутгийн амьжиргаа, уламжлалт хэрэглээний хэрэгцээ, нийгэм, эдийн засаг, экологийн үр нөлөөг судлан тогтооно.

9.3. Ой зохион байгуулалтын үр дүнг үндэслэн ойн бүсийн ангилал, зааг, байршил, талбайн хэмжээг харуулсан зураглалыг үйлдэнэ.

10 дугаар зүйл. Хамгаалалтын бүсийн ой, түүний дэглэм

10.1. Байгаль орчны тэнцвэр, ус, хөрс, уур амьсгал, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор хамгаалалтын бүсийн ойг тогтооно.

10.2. Хамгаалалтын бүсийн ойд дараах ой хамаарна:

10.2.1. усны эх, гол мөрний сав, нуур, рашааны эх, усан сан, бусад усны байгууламжийн эрэг дагуух ус хамгаалалтын бүсэд байрлах ой;

10.2.2. цармын бүслүүр болон өндөр уулын эмзэг экосистем бүхий ой;

10.2.3. тусгай хамгаалалттай газрын ой;

10.2.4. элсний нүүлт, хөрсний эвдрэл, гулсалт, цөлжилтөөс хамгаалах цөл, хагас цөлийн заган ой;

10.2.5. хуш мод зонхилсон экологийн эмзэг бүсийн ой;

10.2.6. татмын ой.

10.3. Хамгаалалтын бүсийн ойд хуульд заасан үндэслэл журмын дагуу дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

10.3.1. ой хамгаалах;

10.3.2. арчилгаа, цэвэрлэгээ;

10.3.3. түймэр, хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ;

10.3.4. ойн нөхөн сэргээлт;

- 10.3.5. шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ;
- 10.3.6. экологийн боловсрол, танин мэдэхүй, ойн аялал жуулчлал;
- 10.3.7. орон нутгийн иргэд ахуйн хэрэглээний түлээний мод авах, хашаа хороогоо сэлбэх;
- 10.3.8. татмын ойд нөхөн сэргээх.
- 10.4. Хамгаалалтын бүсийн ойд дараах үйл ажиллагааг хориглоно:
 - 10.4.1. үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх;
 - 10.4.2. байгалийн сэргэн ургалтыг алдагдуулах;
 - 10.4.3. ойн экосистемд сөрөг нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулах;
 - 10.4.4. химийн бодис ашиглан хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх;
 - 10.4.5. мод, сөөг, заг шилжүүлэн суулгах;
 - 10.4.6. татмын ойд мод огтлох, шилжүүлэх, гэмтээх;
 - 10.4.7. хуульд заасан бусад.

11 дүгээр зүйл. Ашиглалтын бүсийн ой, түүний дэглэм

11.1. Ашиглалтын бүсийн ойн экосистемийн тэнцвэрийг хадгалах нөхцөлтэйгээр ойн баялгийн нөөцөд тулгуурлан экосистемийн үйлчилгээ болон ойн эдийн засгийн үйл ажиллагааг тогтвортой явуулах зорилгоор тогтооно.

11.2. Ашиглалтын бүсийн ойд ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн дараах үйл ажиллагаа явуулж болно:

- 11.2.1. мод бэлтгэх;
- 11.2.2. ойн дагалт баялаг түүх, бэлтгэх;
- 11.2.3. ойн аялал жуулчлал;
- 11.2.4. нүүрстөрөгчийн шингээлт, ялгарлыг бууруулах төсөл хэрэгжүүлэх;
- 11.2.5. ойн зам, дэд бүтцийг төлөвлөх, байгуулах, ашиглах;
- 11.2.6. био-эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх;
- 11.2.7. хуульд тодорхой заасан бусад үйл ажиллагаа.

11.3. Ашиглалтын бүсийн ойн үйл ажиллагаа нь орон нутгийн амьжиргаа, хэрэгцээг харгалзаж болно.

11.4. Ашиглалтын бүсийн ойд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

11.4.1. байгалийн сэргэн ургалтыг алдагдуулах;

11.4.2. зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн ойн баялгийн нөөцийг ашиглах;

11.4.3. менежментийн төлөвлөгөөнд тусгаагүй үйл ажиллагааг явуулах, гэрээгээ зөрчих, тоо хэмжээг хэтрүүлэх;

11.4.4. айгаль орчинд эрсдэлтэй технологи, арга хэрэглэх.

11.5. Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч ашиглалтын ойн бүс дэх ойн аж ахуйн арга хэмжээний хэрэгжилтэд хяналт, шалгалт тавина.

12 дугаар зүйл. Тусгай зориулалтын ой, түүний дэглэм

12.1. Тусгай зориулалтын ойг хамгаалах, хот, суурин газрын ногоон бүсийг хадгалах, түүх, соёлын үнэт зүйлсийг хамгаалах, нийгмийн эрэлт хэрэгцээг хангах зорилгоор тусгай зориулалтын ойг тогтооно.

12.2. Тусгай зориулалтын ойд дараах ойг хамааруулна:

12.2.1. ойн генетик нөөц, материал, ойн үрийн талбай;

12.2.2. шинжлэх ухааны туршилт, сургалт, судалгааны ой;

12.2.3. хот, суурины ногоон бүсийн ой;

12.2.4. түүх, соёлын ач холбогдол бүхий ой;

12.2.5. хот, суурин газар, зам, инженерийн байгууламж, хөдөө аж ахуйн эдэлбэрийг хамгаалах зурвас ой, агро-ой.

12.3. Тусгай зориулалтын ойд менежментийн төлөвлөгөөг үндэслэн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

12.3.1. ой хамгаалал, арчилгаа, цэвэрлэгээ;

12.3.2. нөхөн сэргээлт, ойжуулалт;

12.3.3. шинжлэх ухааны судалгаа, шинжилгээ;

12.3.4. сургалт, дадлага, экологийн боловсрол;

12.3.5. ойн аялал жуулчлал;

12.3.6. уламжлалт хэрэглээ.

12.4. Тусгай зориулалтын ойд дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

12.4.1. үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх;

12.4.2. ойн дагалт баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах;

12.4.3. ойд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулах;

12.4.4. тухайн ойн дэглэмд нийцэхгүй барилга, байгууламж барих;

12.4.5. төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төсөл.

12.5. Тусгай зориулалтын ой нь тусгай хамгаалалттай газар нутаг, соёлын өв, хот байгуулалтын бүсэд давхар хамаарах тохиолдолд энэ хуульд заасан дэглэмээс гадна холбогдох хууль тогтоомжид заасан дэглэмийг мөрдөнө.

Тайлбар: Энэ хуулийн 12.2.3-т заасан “ногоон бүсийн ой” гэдэгт хот, суурин газрын орчны уур амьсгалын нөлөөллийг бууруулах, экологийн тэнцвэрийг хадгалах, иргэдийн амралт, аялал жуулчлалын эрүүл таатай орчныг бүрдүүлэх зориулалтаар тогтоосон экосистемийн үйлчилгээ бүхий байгалийн ой хамаарна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТ

13 дугаар зүйл. Ойн тогтвортой менежментийн зарчим

13.1. Ойн тогтвортой менежмент нь ойн экологийн тэнцвэртэй байдал, эдийн засгийн үр өгөөж, нийгмийн ашиг тусын тулд ойн баялгийн нөөцийг урт хугацаанд хариуцлагатайгаар удирдахад чиглэнэ.

13.2. Ойн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд дараах нийтлэг зарчмыг баримтална:

13.2.1. эрүүл ойг хадгалах, байгалийн нөхөн сэргэлтийг дэмжих, биологийн олон янз байдлыг хамгаалах;

13.2.2. уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд нийгмийн сайн сайхан байдалд хувь нэмэр оруулах;

13.2.3. нүүрстөрөгчийн шингээлтийг хадгалах, ялгарлыг бууруулах;

13.2.4. ой нөөцийн бүтээгдэхүүн, экосистемийн үйлчилгээг уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй эдийн засгийн үйл ажиллагаанд чиглүүлэх.

13.3. Ойн менежментийн зарчмыг улс, аймаг, нийслэл, сум, зарим дүүргийн ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-үнэлгээ, шинжилгээ хийхэд баримтална.

14 дүгээр зүйл. Ойн менежментийн төлөвлөгөө

14.1. Ойн менежментийн төлөвлөгөө нь ойн баялгийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, ангилах, бүсчлэх, эрсдэлийг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэгдсэн стратеги төлөвлөлтийн баримт бичиг байна.

14.2. Ойн менежментийн төлөвлөгөө нь доор дурдсан төлөвлөгөөнөөс бүрдэнэ:

14.2.1. улсын ойн менежментийн төлөвлөгөө;

14.2.2. аймаг, нийслэлийн менежментийн төлөвлөгөө;

14.2.3. сумын ойн менежментийн төлөвлөгөө.

14.3. йн менежментийн төлөвлөгөөг ойн тооллого, ой зохион байгуулалтын дүнг үндэслэн боловсруулна.

14.4. Сумын ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэх явцад төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, нөхөрлөл, хувийн хэвшил, мэргэжлийн холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, орон нутгийн иргэд, олон нийтийн саналыг авна.

14.5. Ойн менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайланг ойн мэдээллийн цахим системд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлнэ.

14.6. Ойн менежментийн төлөвлөгөөг арван жил тутам батлах ба хугацаанаас өмнө дараах үндэслэлээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

14.6.1. байгалийн гамшигт үзэгдлийн улмаас ойн төлөв байдалд ихээхэн хэмжээний өөрчлөлт орсныг эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон бол;

14.6.2. газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ойн сан бүхий газрын ангилалд өөрчлөлт орсон бол.

14.7. Ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулах аргачлалыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

15 дугаар зүйл. Улсын ойн менежментийн төлөвлөгөө

15.1. Улсын ойн менежментийн төлөвлөгөөг Засгийн газар батална.

15.2. Улсын ойн менежментийн төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

15.2.1. цөлжилтөөс сэргийлэх, бууруулах, сааруулах, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой улсын хэмжээнд хэрэгжих ойжуулалтын төсөл;

15.2.2. улсын төсвөөс санхүүжүүлж хэрэгжүүлэх ойн аж ахуйн арга хэмжээ;

15.2.3. Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн бусад ойжуулах төсөл.

15.3. Улсын ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалтын төсөл, ойн аж ахуйн арга хэмжээ, хэрэгжүүлэх арга зам, үе шат, санхүүгийн эх үүсвэр, хүрэх дүн, шалгуур үзүүлэлт, хяналт үнэлгээ, шинжилгээ хийх асуудлыг тусгасан байна.

15.4. Улсын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хангуулна.

15.5. Улсын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна.

15.6. Улсын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ойжуулалтын төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах ажлыг ойн асуудал хариуцсан төрийн байгууллага хариуцан зохион байгуулна.

15.7. Техник, эдийн засгийн үндэслэлийг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж баталгаажуулна.

15.8. Улсын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ойжуулалтын төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг холбогдох хуулийн дагуу хийнэ.

16 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөө

16.1. Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

16.2. Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөө нь тухайн нутаг дэвсгэрийн ойн бүсийн ангилал, дэглэм, эрсдэлийн түвшинд нийцсэн байна.

16.3. Аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

16.3.1. улсын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан өөрийн нутаг дэвсгэрт хамаарах ойн аж ахуйн арга хэмжээ;

16.3.2. аймаг, нийслэлийн хэмжээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх ойн аж ахуйн арга хэмжээ.

17 дугаар зүйл. Сумын ойн менежментийн төлөвлөгөө

17.1. Сумын ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал батална.

17.2. Сумын ойн менежментийн төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана:

17.2.1. ойн бүсийн ангилал, зааг, талбай;

17.2.2. хамгаалалт, ашиглалт, нөхөн сэргээлтийн бүсчилсэн арга хэмжээ;

17.2.3. ашиглалтын хэмжээ, нөхцөл, дараалал;

17.2.4. ойжуулалт, нөхөн сэргээлт, цэвэрлэгээ, арчилгаа, хамгаалалтын арга хэмжээ;

17.2.5. түймэр, хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ;

17.2.6. самар, ойн дагалт баялаг, аялал жуулчлал, агро-ойн аж ахуйн зохицуулалт;

17.2.7. орон нутгийн иргэд, нөхөрлөл, хоршоо, малчин, малчин өрхийн холбоо, хувийн хэвшлийн оролцоо;

17.2.8. орон нутгийн иргэдийн уламжлалт хэрэглээ, эрхийг харгалзсан зохицуулалт;

17.2.9. орон нутгийн орлогын хуваарилалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн санхүүжилт;

17.2.10. хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналын тогтолцоо.

17.3. Сумын ойн менежментийн төлөвлөгөөтэй тусгай хамгаалалтын газар нутгийн менежментийн төлөвлөгөөг уялдуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ОЙН ЭДИЙН ЗАСАГ

18 дугаар зүйл. Таримал ойг өмчлөх, эзэмшиж ашиглах

18.1. Дараах газарт иргэн, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр мод, сөөгийг тарьж ургуулж, үр шимийг хүртэж болно:

18.1.1. Монгол Улсын иргэн өмчлөлийн газартаа;

18.1.2. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа газартаа;

18.1.3. улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалт хийхээр төлөвлөсөн газарт.

18.2. Монгол Улсын иргэн өмчлөлийн газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ой, мод, сөөгийг өмчилж болно.

18.3. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд эзэмшиж байгаа газартаа өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ой, мод, сөөгийг эзэмшиж, ашиглаж болно.

18.4. Улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалт хийхээр төлөвлөсөн газарт өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ойг эзэмшиж, ашиглаж болно.

18.5. Энэ хуулийн 18.1.3-т заасан газарт ойжуулалтыг хуулийн этгээд хамтран хийж болно.

18.6. Энэ хуулийн 18.5-д заасны дагуу хамтран ойжуулалт хийсэн тохиолдолд таримал ойн үр шимийг хүртэх асуудлыг талуудын байгуулсан гэрээгээр шийдвэрлэнэ.

18.7. Энэ хуулийн 18.1.2-т заасны дагуу ойжуулалтын зориулалтаар эзэмшүүлэх газрыг олгох асуудлыг төсөл сонгон шалгаруулах замаар шийдвэрлэнэ.

18.8. Улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалт хийхээр төлөвлөсөн газрыг улсын болон орон нутгийн хэрэгцээнд авах асуудлыг Газрын хуулиар зохицуулна.

18.9. Улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалт хийхээр төлөвлөсөн газарт ойжуулалт хийх хуулийн этгээдийг төсөл сонгон шалгаруулалтаар сонгоно.

18.10. Иргэн, хуулийн этгээд нь өөрийн хөрөнгөөр тарьж ургуулсан таримал ойг бүртгүүлэх хүсэлтээ сумын болон сум дундын ойн ангид цахимаар гаргана.

18.11. Сумын болон сум дундын ойн анги тухайн иргэн, хуулийн этгээдийн тарьж ургуулсан таримал ой нь энэ хуулийн 3.1.1-д заасан ойн хэв шинжийг хангасан эсэхийг шалгаж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

18.11.1. ойн хэв шинжийг хангасан гэж үзвэл ойн мэдээллийн цахим системд тухайн таримал ойг бүртгэж, цахим гэрчилгээ олгоно.

18.11.2. ойн хэв шинжийг хангаагүй гэж үзсэн бол ойн мэдээллийн цахим системд тухайн таримал ойг бүртгэхгүй;

18.11.3. энэ хуулийн 18.11.2-т заасны дагуу таримал ойгоор бүртгээгүй тохиолдолд тарьсан мод, сөөгийг ойн мэдээллийн цахим системд бүртгэх.

18.12. Таримал ойн цахим гэрчилгээний загварыг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

18.13. Таримал ойг эзэмшиж ашиглаж байгаа этгээд нь таримал ойн үр шимийг захиран зарцуулна.

18.14. Энэ хуулийн 18.1.1-д заасан өөрийн өмчлөлийн газраа худалдсан тохиолдолд тухайн газар дээрх таримал ой хамт шилжинэ.

18.15. Таримал ойг эзэмшиж ашиглаж байгаа тохиолдолд таримал ойг өвлүүлэхээс бусад хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

18.16. Ойжуулах зориулалтаар эзэмшиж байгаа газарт тарьсан таримал ойг эзэмшиж ашиглах хугацаа нь газар эзэмших хугацаатай нэгэн адил байна.

18.17. Улс, аймаг, нийслэлийн ойн менежментийн төлөвлөгөөнд ойжуулалт хийхээр төлөвлөсөн газарт таримал ой эзэмшиж, ашиглах хугацаа 10 жилийн давтамжтайгаар 60 хүртэл жил байна.

18.18. Энэ хуулийн 18.1-д заасан газарт тарьж ургуулсан таримал ойд ойн тооллого, ой зохион байгуулалтыг энэ хуульд заасны дагуу хийнэ.

18.19. Таримал ойг өмчлөгч иргэн, эзэмшиж ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээд нь тухайн ойг хамгаалах, түймэр, хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, доройтлоос хамгаалах болон ойн зохион байгуулалтын арга хэмжээг өөрийн хөрөнгөөр хийх ба холбогдох стандарт, техникийн зохицуулалтыг мөрдөх үүрэгтэй.

19 дүгээр зүйл. Ойн сан бүхий газрыг хариуцуулах

19.1. Харьяалах нутаг дэвсгэрийн ойн сан бүхий газар нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн эзэмшилд байна.

19.2. Ойн сан бүхий газрын тодорхой хэсгийг хамгаалах, нөхөн сэргээх, хадгалах зориулалтаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор гэрээний дагуу хот айл, нөхөрлөлд хариуцуулж болно.

19.3. Энэ хуулийн 19.2-т заасан хот айл, нөхөрлөлд хариуцуулах ойн сангийн тодорхой хэсэг нь сумын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан байна.

19.4. Хот айл, нөхөрлөлд гэрээгээр арван жилийн давтамжтайгаар 60 хүртэл жилийн хугацаагаар хариуцуулж болно.

19.5. Ойн сан бүхий газрын тодорхой хэсгийг хариуцан хамгаалж байгаа хот айл, нөхөрлөл нь сумын ойн менежментийн төлөвлөгөөний дагуу ойг хамгаалах, гэрээнд заасны дагуу босоо хатсан, унанги модыг цэвэрлэгээний зориулалтаар авч ашиглаж болно.

19.6. Нөхөрлөл, хот айл тухайн ойн ангиллын дэглэмд нийцүүлэн сумын ойн менежментийн төлөвлөгөөний дагуу түлээний мод, дагалт баялгийг ашиглах, бусад хэлбэрээр ойн баялгийн нөөцөөс үр шимийг нь хүртэх эрхтэй.

19.7. Нөхөрлөл, хот айлын хариуцаж байгаа ойн сан бүхий газарт мал туувар дайран өнгөрөх, мал бэлчээх, зөгий үржүүлэх, өвс хадах болон бусад иргэн, хуулийн этгээд аялал зугаалгаар явах, хуульд заасны дагуу авсан зөвшөөрлийн үндсэн дээр хот айл, нөхөрлөлийн хяналт дор мод бэлтгэж, ойн дагалт баялаг ашиглаж болно.

19.8. Энэ хуулийн 19.7-д заасан этгээд тухайн ойн сан бүхий газрын тодорхой хэсэгт хохирол учруулсан тохиолдолд учирсан хохирлыг арилгана.

19.9. Хариуцаж хамгаалж байгаа ойн сан бүхий газрын тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх, түрээслэх, барьцаалахыг хориглоно.

19.10. Нөхөрлөл, хот айл нь өөрийн хариуцаж байгаа ойн сан бүхий газрын ойн нүүрстөрөгчийн кредитийн зах зээлд оролцож болно.

20 дугаар зүйл. Ойн эдийн засгийн үйл ажиллагаа

20.1. Ойн эдийн засгийн үйл ажиллагаа нь ойн баялгийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, ойн экосистемийн үйлчилгээний эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээнээс бүрдэнэ.

20.2. Ойн эдийн засгийн үйлдвэрлэл, үйлчилгээнд дараах нийтлэг шаардлага тавигдана:

20.2.1. тухайн ойн бүсийн ангилал, дэглэмд нийцсэн байх;

20.2.2. ойн менежментийн төлөвлөгөөнд үндэслэсэн байх;

20.2.3. дэвшилтэт, ногоон технологи ашигласан байх;

20.2.4. ойн баялгийн нөөцийг хаягдалгүй үр ашигтай, тогтвортой ашиглах, хаягдлыг бууруулах, үлдэгдэл биомассыг био-эдийн засгийн эргэлтэд оруулах.

20.2.5. ойн баялгийн нөөцийн гарал үүсэл тодорхой байх, ул мөрийг мөшгөх тогтолцоог нэвтрүүлсэн байх;

20.2.6. ойн баялгийн нөөцийн гарал үүсэл, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын тоо хэмжээг цахим системд бүртгэх, тайлагнах;

20.2.7. үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, нөхөн сэргээх, хамгаалах санхүүжилтийн эх үүсвэртэй байх;

20.2.8. орон нутгийн иргэд, нөхөрлөлийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзсан байх;

20.2.9. холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангах;

20.2.10. хуульд заасан бусад.

Тайлбар: Энэ хуулийн 20.2.4-т заасан “Үлдэгдэл биомасс” гэдэгт ойн баялгийн нөөцийг бэлтгэх, боловсруулах, ашиглах явцад үүссэн, дахин боловсруулах боломжтой органик гаралтай үлдэгдэл материал хамаарна.

21 дүгээр зүйл. Ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

21.1. Ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь ойн модны нөөц, ойн дагалт баялаг, ойн биомасст суурилсан байна.

21.2. Ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дараах үйл ажиллагаа хамаарна:

21.2.1. мод бэлтгэх;

21.2.2. мод боловсруулах;

21.2.3. ойн дагалт баялгийг түүж бэлтгэх, боловсруулах;

21.2.4. био-эдийн засгийн үйлдвэрлэл эрхлэх;

21.2.5. хуульд нийцсэн, ойн менежментийн зорилгод харшлахгүй бусад үйлдвэрлэл эрхлэх.

22 дугаар зүйл. Мод бэлтгэх

22.1. Сумын болон сум дундын ойн анги нь сумын менежментийн төлөвлөгөөнд заасан хэмжээнд багтаан бэлтгэх модны нөөцийн хэмжээг жил бүр гаргаж, хуваарилна:

22.1.1. иргэдийн ахуйн болон уламжлалт хэрэглээнд зориулсан модыг баг тус бүрээр;

22.1.2. арчилгаа, цэвэрлэгээг тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд тус бүрээр;

22.1.3. үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх модны нөөцийг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд тус бүрээр.

22.2. Үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэлийг төсөл сонгон шалгаруулалтын үндсэн дээр гүйцэтгэнэ.

22.3. Зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн бэлтгэх, зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэхийг хориглоно.

22.4. Өөр сумын нутаг дэвсгэрт мод бэлтгэх тохиолдолд холбогдох сумын Засаг дарга нар урьдчилан тохиролцож, тухайн жилийн мод бэлтгэлийн хуваарьт тусгуулах саналыг сумын болон сум дундын ойн ангид хүргүүлнэ.

22.5. Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд, нөхөрлөл, иргэн мод бэлтгэх хүсэлтээ тухайн орон нутгийг хариуцсан сумын болон сум дундын ойн ангид цахим системээр дамжуулан гаргана.

22.6. Хүсэлтийг энэ хуулийн 22.1-д заасан зориулалтын дагуу цахим эрхийн бичиг олгоно.

22.7. Ойгоос бэлтгэсэн мод, модон материалыг аймаг, сум, хот, суурины хооронд тээвэрлэх, худалдахдаа цахим гарал үүслийн гэрчилгээтэй байна.

22.8. Гарал үүслийн гэрчилгээг тухайн орон нутгийг хариуцсан сум болон сум дундын ойн анги цахим системээр олгоно.

22.9. Мод бэлтгэх цахим эрхийн бичиг, мод, модон материалын цахим гарал үүслийн гэрчилгээний загварыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

22.10. Засгийн газар дотоодын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор боловсруулаагүй модны экспортод хязгаарлалт тогтоож болно.

22.11. Ахуйн зориулалтаар бэлтгэсэн түлээний модыг ашиг олох зорилгоор худалдахыг хориглоно.

23 дугаар зүйл. Үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх гэрээ

23.1. Энэ хуулийн 22.2-т заасан сонгон шалгаруулалтад тэнцсэн тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдтэй сум болон сумын ойн анги, сумын Засаг дарга үйлдвэрлэлийн зориулалтаар модны нөөц ашиглах тухай гурвалсан гэрээ байгуулна.

23.2. Гэрээнд дараах зүйлийг тусгана:

23.2.1. үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгүүлэх үндэслэл /зохих шийдвэр/;

23.2.2. зориулалт, бэлтгэх хэмжээ болон хугацаа;

23.2.3. мод бэлтгэх талбайн хэмжээ, байршил, заагийг харуулсан зураг, хэсэглэл, ялгарлын дугаар;

23.2.4. талуудын эрх, үүрэг, хариуцлага;

23.2.5. менежментийн төлөвлөгөөний дагуу хамгаалах, арчлах, нөхөн сэргээх;

23.2.6. гэрээг дүгнэх, цуцлах, түдгэлзүүлэх, хүчингүй нөхцөл;

23.2.7. шаардлагатай гэж үзсэн бусад зүйл.

23.3. Гэрээг дүгнэж, гэрээний үүргээ биелүүлээгүй, ойд хохирол учруулсан бол гэрээг цуцалж, хохирлыг арилгуулна.

23.4. Үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэгч нь дараах үүрэгтэй байна:

23.4.1. ашиглалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөтэй байх;

23.4.2. мэргэжлийн хүний нөөц, техник, тоног төхөөрөмжтэй байх, техник, аюулгүй ажиллагааны нөхцөлийг хангасан байх;

23.4.3. гарал үүсэл нь тодорхой, бэлтгэл, тээвэрлэлт, худалдааны бүртгэл хөтөлсөн байх.

23.5. Үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэгч нь бэлтгэсэн модны мэдээллийг ойн мэдээллийн цахим системд тухай бүр бүртгэнэ.

23.6. Үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэгч нь мод бэлтгэлийн үйл явцад энэ хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийлгэж болно.

24 дүгээр зүйл. Мод боловсруулах үйлдвэрлэл

24.1. Ашиглалтын бүсийн ойгоос бэлтгэсэн, гарал үүсэл нь тодорхой түүхий эдэд тулгуурлан холбогдох стандарт, техникийн зохицуулалтын дагуу мод боловсруулах үйлдвэрлэлийг явуулна.

24.2. Мод боловсруулах үйлдвэрлэл эрхлэгч нь үйлдвэрлэлийн үйл явцад энэ хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу баталгаажуулалт хийлгэж болно.

25 дугаар зүйл. Ойн дагалт баялгийг түүж бэлтгэх, боловсруулах

25.1. Ойн дагалт баялгийг түүж бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаанд дараах шаардлага тавигдана:

25.1.1. нөөц, нөхөн сэргээлтийн чадавхад үндэслэсэн байх;

25.1.2. түүж бэлтгэх тоо хэмжээ, бүсчлэл, хугацааг мөрдөх.

25.2. Ойн дагалт баялгийг түүж бэлтгэхэд орон нутгийн иргэд, нөхөрлөл давуу эрхтэй.

25.3. Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ойн дагалт баялгийг түүж бэлтгэхэд хязгаарлалт тогтоож болно.

25.4. Ойн дагалт баялгийг түүний байгалийн сэргэн ургалтад сөрөг нөлөө үзүүлэх арга хэлбэрээр бэлтгэхийг хориглоно.

26 дугаар зүйл. Хушин ойн менежмент

26.1. Хушны самрын биологийн ургацаас хамааран ашиглах нөөцийг сумын болон сум дундын ойн анги тогтоож, ойн мэдээллийн цахим системд илгээнэ.

26.2. Цахим системд илгээсэн ашиглалтын нөөцийг хянаж, нөөцийн хэмжээг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

26.3. Хушны самрын биологийн ургац, ашиглах нөөцийг тогтоох аргачлалыг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

26.4. Хушин ой нь экологийн хувьд эмзэг, эдийн засгийн ач холбогдолтой тул тусгайлсан менежментийн дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

26.4.1. самрын нөөц, ашиглах хэмжээ, хугацаа, тоо хэмжээг тогтоох;

26.4.2. байгальд ээлтэй дэвшилтэд технологи ашиглах;

26.4.3. байгалийн сэргэн ургалтыг дэмжих;

26.4.4. хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хяналт тавих;

26.4.5. түймэр, хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх, тэмцэх;

26.4.6. хөрс, үндсийг хамгаалах;

26.4.7. самрыг хуваарилалтын дагуу ашиглах;

26.4.8. доройтсон талбайд нөхөн сэргээлт хийх.

26.5. Хушин ойд иргэн, хуулийн этгээдээс дараах үйл ажиллагааг явуулахыг хориглоно:

26.5.1. байгальд халтай, механик аргаар самар түүх, бэлтгэх;

26.5.2. байгалийн сэргэн ургалтыг устгах;

26.5.3. хөрс, үндэс гэмтээх;

26.5.4. зөвшөөрөлгүй ашиглах.

27 дугаар зүйл. Био-эдийн засгийн үйлдвэрлэл

27.1. Био-эдийн засгийн үйлдвэрлэлд био түлш, ойн химийн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдэд суурилсан бусад бүтээгдэхүүний үйлдвэрлэл хамаарна.

27.2. Био-эдийн засгийн нэрээр байгалийн ойг хэт ашиглахыг хориглоно.

28 дугаар зүйл. Төрөөс үзүүлэх дэмжлэг

28.1. Дараах ойн чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд төрөөс дэмжлэг үзүүлж болно:

28.1.1. ногоон дэвшилтэт технологийн шинэчлэл;

28.1.2. нөхөрлөл, хот айл хариуцан хамгаалж байгаа ойн сан бүхий газарт гэрээнд заасны дагуу босоо хатсан, унанги модыг цэвэрлэгээний зориулалтаар авч ашигласан бол;

28.1.3. орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл, агро-ойн аж ахуйн үйлдвэрлэл болон экспортын үйлдвэрлэл;

28.1.4. хүний нөөцийг чадавхжуулах, мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх;

28.1.5. нөхөрлөл, хот айлын чадавхыг бэхжүүлэх сургалт, арга зүйн зөвлөгөө;

28.1.6. экспорт, кластер, логистикийн дэмжлэг;

28.1.7. ойн тогтвортой менежментийн баталгаажуулалт.

28.2. Үлдэгдэл биомассын боловсруулах үйлдвэрлэлийг тэргүүн ээлжид дэмжинэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

ОЙЖУУЛАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

29 дүгээр зүйл. Ойн үр, үржлийн материал бэлтгэх

29.1. Ойн нөхөн сэргээлт, ойжуулалтын ажилд ашиглах болон ойн үрийн улсын нөөцийн санд худалдан авах үр, үржлийн материал нь тухайн ойн үрийн мужлалаас гарал үүсэлтэй, стандартын шаардлага хангасан байна.

29.2. Ойн үрийн мужлалын хилийн заагийг шинжлэх ухааны байгууллагын саналыг үндэслэн ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тогтооно.

29.3. Ойн үр, үржлийн материалын гарал үүслийн гэрчилгээг ойн анги цахимаар олгоно.

29.4. Ойн үржлийн материалын гарал үүслийн гэрчилгээнд тухайн үржлийн материал нь холбогдох стандартыг хангаж байгаа эсэхийг тусгана.

29.5. Гарал үүслийн гэрчилгээтэй ойн үрийн шинжилгээг итгэмжлэгдсэн лаборатори хийж, дүнг ойн мэдээллийн цахим системд илгээнэ.

29.6. Лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага үрийн чанарын цахим гэрчилгээг олгоно.

29.7. Байгалийн гамшгийн улмаас үр нөөцөлж чадаагүй, эсхүл үрийн бага ургацын жилд иргэн, хуулийн этгээд, байгууллагад үр нийлүүлэх, үр шинэчлэх зорилгоор удамшлын болон тарилтын сайн чанарын үрээр ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зөвшөөрлөөр ойн үрийн улсын нөөцийн санг бүрдүүлнэ.

29.8. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд улсын ойн үрийн нөөцийн сан, итгэмжлэгдсэн лаборатори ажиллана.

29.9. Ойн үрийн шинжилгээ хийлгэхтэй холбогдсон зардлыг үр бэлтгэсэн этгээд хариуцна.

29.10. Гарал үүсэл нь тодорхойгүй, эсхүл итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээгээр стандартын шаардлага хангаагүй болох нь тогтоогдсон үр, үржлийн материалын улсын нөөц бүрдүүлэх, зах зээл дээр худалдах, ашиглахыг хориглоно.

29.11. Энэ хуулийн 29.1-д заасан шаардлага нь импортлох үр, үржлийн материалд адил үйлчилнэ.

29.12. Тухайн ойн үрийн мужлалын үр, үржлийн материалыг өөр мужлалд тарихыг хориглоно.

29.13. Байгалийн ойн нөхөн сэргээхэд харь зүйлийн мод, сөөг, үржлийн материал тарих, ашиглах болон ойн үрийн улсын нөөцийн санд харь үр, үржлийн материал авахыг хориглоно.

29.14. Нөхөн сэргээлтэд ашиглах болон ойн үрийн улсын нөөцийн санд худалдан авах ойн үр, үржлийн материал нь харь зүйл мөн эсэх талаар ойн эрдэм шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байна.

30 дугаар зүйл. Мод, сөөгний тарьц, суулгацыг импортлох, нутагшуулах туршилт судалгаа хийх

30.1. Импортоор оруулж ирэх харь, эсхүл устсан унаган зүйлийн мод, сөөгний тарьц, суулгацыг Монгол Улсын нутаг дэвсгэрт нутагшуулах туршилт судалгаа (цаашид “нутагшуулах туршилт судалгаа”)-г батлагдсан арга зүйн дагуу ойн шинжилгээний байгууллага хийнэ.

30.2. Мод, сөөгний зүйлээс хамаарч нутагшуулах туршилт судалгааны хугацаа нь харь зүйлийн хувьд 5-аас доошгүй, устсан унаган зүйлийн хувьд 3-аас доошгүй жилийн хугацаанд хийгдсэн байна.

30.3. Нутагшуулах туршилт судалгааг хийсэн эрдэм шинжилгээний байгууллага нь үр дүнгээ нөөцийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, цаашид тарималжуулах боломжтой эсэх талаар зөвлөмж гаргуулж, ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

30.4. Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 30.2, 30.3-т заасан мод, сөөгний тарьц, суулгацыг ойн мэдээллийн цахим санд бүртгэж, нийтэд мэдээлснээр иргэн, хуулийн этгээд харь зүйлийг хот, суурингийн ногоон байгууламжид болон ойжуулалтад тарих боломж бүрдэнэ.

30.5. Харь болон утсан унаган зүйлийг мод, сөөгийн тарьц, суулгацыг туршилт судалгааны зориулалтаар импортлоход дараах шаардлага тавигдана:

30.5.1. нутагшуулах туршилт судалгаа хийх өөрийн эзэмшлийн мод үржүүлгийн газартай байх, эсхүл бусдын мод үржүүлгийн газарт хийхээр гэрээ байгуулсан байх;

30.5.2. эрдэм шинжилгээний байгууллагатай нутагшуулах туршилт судалгаа хийлгэхээр гэрээ байгуулсан байх;

30.5.3. импортлогч улсын генийн өөрчлөлтгүйг батлах баримт бичигтэй байх;

30.5.4. харь зүйл мөн эсэх талаар ойн шинжилгээний байгууллагаар дүгнэлт гаргуулсан байх.

30.6. Нэг зүйлийн мод, сөөгийн тарьц суулгацыг импортлох дээд хэмжээ 200 ширхэг хүртэл байна.

30.7. Монгол Улсын нутаг дэвсгэрт нутагшуулах туршилт судалгааны зориулалтаар импортоор орж ирж байгаа мод, сөөгийн тарьц, суулгацыг хилээр нэвтрүүлэхтэй холбогдсон харилцааг Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулиар зохицуулна.

30.8. Ой, мод, сөөг тарьж ургуулсан иргэн, нөхөрлөл, хуулийн этгээдийг урамшууллыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал орон нутгийн төсөвт тусгана.

31 дүгээр зүйл. Ойжуулалт

31.1. Ойжуулалтыг ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн дараах чиглэлээр хэрэгжүүлнэ:

31.1.1. бэлчээр, тариалангийн талбайг хамгаалах, агро ойг хөгжүүлэх;

31.1.2. баянбүрд, хөв цөөрөм, усан сан, ус намгархаг газрыг хамгаалах;

31.1.3. цөлжилт, хөрсний доройтол, элсний нүүлтээс хамгаалах;

31.1.4. төрөл бүрийн зориулалтаар хамгаалалтын ойн зурвас байгуулах;

31.1.5. гол горхи, булаг шанд, хөв цөөрөм хамгаалах;

31.1.6. жимс, жимсгэнийн цэцэрлэг.

31.2. Ойжуулалт нь дараах шаардлагыг хангасан байна:

31.2.1. тухайн бүс нутгийн уур амьсгал, хөрс, ургамлын аймагт нийцсэн байх;
31.2.2. унаган мод, сөөгний төрөл зүйлийг ашиглах;
31.2.3. биологийн олон янз байдлыг нэмэгдүүлэх;
31.2.4. ус, хөрс хамгаалах, нүүрстөрөгч шингээлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх.

31.3. Ойжуулалтыг төр, орон нутгийн байгууллага, нөхөрлөл, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотой хэрэгжүүлж болно.

31.4. Ойжуулалтын ажлын гүйцэтгэл, чанарыг үнэлж баталгаажуулж, мэдээллийг ойн мэдээллийн цахим системд бүртгэнэ.

31.5. Ойжуулалтыг дэмжих зорилгоор татвар, санхүүжилт, урамшууллын арга хэмжээг хэрэгжүүлж болно.

32 дугаар зүйл. Нөхөн сэргээлт

32.1. Нөхөн сэргээлт нь түймэр, хөнөөлт организм, ой ашиглалт, доройтол, байгалийн болон хүний үйл ажиллагааны улмаас эвдэрсэн ойн экосистемийг сэргээх, байгалийн сэргэн ургалтыг дэмжих үйл ажиллагаа байна.

32.2. Нөхөн сэргээлтийг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

32.2.1. байгалийн сэргэн ургалтыг дэмжих;

32.2.2. арчилгаа, цэвэрлэгээ хийсэн талбайд;

32.2.3. үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэсэн талбайд;

32.2.4. хөрс, ус хамгаалалтын арга хэмжээ;

32.2.5. техникийн болон биологийн нөхөн сэргээлт.

32.3. Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд, нөхөрлөл нь энэ хуулийн 32.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

32.4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг ашиглалт эхлэхээс өмнө сумын болон сум дундын ойн ангиар батлуулж, шаардлагатай санхүүгийн баталгааг ойн ангийн дансанд байршуулна.

32.5. Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийг сумын Засаг дарга байгуулсан ажлын хэсэг үнэлж хүлээн авна.

32.6. Нөхөн сэргээлтийн үр дүн хангалтгүй гэж тогтоогдсон тохиолдолд нөхөн тарилтыг хийлгүүлнэ.

32.7. Нөхөн сэргээлтийн мэдээлэл, явцыг ойн мэдээллийн цахим системд бүртгэж, олон нийтэд ил тод мэдээлнэ.

33 дугаар зүйл. Агро-ойн аж ахуй

33.1. Агро-ойн аж ахуй нь ой, мод, сөөг тариалалтыг тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлсэн, нийгэм, эдийн засаг, байгаль орчны ашиг тустай, орон нутгийн иргэдийн амьжиргааг дэмжих үйлдвэрлэл байна.

33.2. Агро-ойн аж ахуйг дараах чиглэлээр хөгжүүлнэ:

33.2.1. мод, сөөг тариалалтыг тариалангийн үйлдвэрлэлтэй хослуулан;

33.2.2. мод, сөөг тариалалтыг мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан;

33.2.3. мод, сөөгийг тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан.

33.3. Агро-ойн аж ахуй нь хөдөө аж ахуйн газарт хэрэгжинэ.

33.4. Агро-ойн аж ахуйг нөхөрлөл, хоршоо, иргэн, хуулийн этгээд хэрэгжүүлж болно.

33.5. Төрөөс агро-ойн аж ахуйд сургалт, санхүүжилт, технологи, арга зүйн дэмжлэг үзүүлж болно.

34 дүгээр зүйл. Бүх нийтээр мод, сөөг тарьж ургуулах ажлыг зохион байгуулах

34.1. Нийслэл, аймаг, улсын чанартай хот, сумын Засаг дарга нар улс даяар бүх нийтээр мод тарих ажлыг жил бүр хавар, намрын улиралд зохион байгуулна.

34.2. Тухайн засаг захиргааны нэгжийн Засаг дарга, түүний тамгын газар нь мод тарих, мод сонгох асуудлаар ойн анги, сум дундын ойн ангиас урьдчилан зөвлөгөө авч, иргэдийг өргөнөөр хамран оролцуулах ажлыг зохион байгуулна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БОЛОН НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

35 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

35.1. Засгийн газар ойн салбарын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

35.1.1. улсын ойн менежментийн төлөвлөгөөг батлах;

35.1.2. аймаг, нийслэлийн ойн асуудал хариуцсан нэгж буюу ойн асуудал хариуцсан албан тушаалтан, сумын болон сум дундын ойн ангийн бүтэц, байршлыг тогтоох;

35.1.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

36 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

36.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ойн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

36.1.1. ойн салбарын бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах хяналт тавих;

36.1.2. жил бүр ашиглах ойн дагалт баялгийн нөөцийн дээд хэмжээг тогтоох;

36.1.3. хил дамнасан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах талаар бусад улстай гэрээ, хэлэлцээр байгуулж, хамтран ажиллах;

36.1.4. ойн баялгийн нөөц, ойн дагалт баялгийг ашиглах, импортлох, экспортлох хэмжээг хуульд заасан үндэслэлээр хязгаарлах буюу тодорхой хугацаагаар хориглох;

36.1.5. ойн экологи, эдийн засгийн үнэлгээг батлах;

36.1.6. ой, хээрийн түймэр гарах өндөр магадлалтай үед хариуцсан нутаг дэвсгэртээ хамгаалалтын дэглэмд заасан зарим үйл ажиллагааг хориглох эрхийг улсын тусгай хамгаалалттай газрын захиргаанд олгох;

36.1.7. хуульд заасан бусад бүрэн эрх.

37 дугаар зүйл. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ойн талаарх бүрэн эрх

37.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ойн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

37.1.1. ойн баялгийн нөөцийг иж бүрэн боловсруулах үйлдвэрлэлийг бодлого, зохицуулалтаар хангах;

37.1.2. ойн баялгийн нөөц ашиглалтын нэмэгдсэн өртгийн сүлжээг хөгжүүлэх, зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;

37.1.3. мод боловсруулах салбарын хүний нөөцийн урт хугацааны бодлогыг салбарын эрэлт хэрэгцээнд үндэслэн боловсруулах, хэрэгжүүлэх;

37.1.4. тариалангийн талбай, бэлчээр хамгаалах ойн зурвас байгуулах, агро-ойн аж ахуйг хөгжүүлэх бодлого, зохицуулалтаар хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

37.1.5. мод боловсруулах, модон бүтээгдэхүүний түүхий эдийн гарцыг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах технологийн судалгаа хийх, технологи дамжуулалтад санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх.

38 дугаар зүйл. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, чиг үүрэг

38.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид "төрийн захиргааны байгууллага" гэх/, аймгийн ойн асуудал хариуцсан албан тушаалтан, сумын болон сумын ойн анги /цаашид "ойн анги" гэх/ ажиллана.

38.2. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байна.

38.3. Сумын болон сум дундын ойн ангийн дарга, ажилтан нь төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагч байна.

38.4. Сумын болон сум дундын ойн ангийн даргыг сумын Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

38.5. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

38.5.1. ойн тогтвортой менежментийн хэрэгжилтийг зохицуулах, уялдааг хангах;

38.5.2. ойн ашиглалт, нөхөн сэргээлт, ойжуулалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх;

38.5.3. ойн мэдээллийн цахим системийг хөтлөх, хөгжүүлэх;

38.5.4. сумын болон сум дундын ойн анги, нөхөрлөлд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах;

38.5.5. ойн үрийн улсын нөөцийн сан байгуулах, баяжуулах, үйл ажиллагааг эрхлэх, үржлийн материал бэлтгэх;

38.5.6. экологи, эдийн засгийн үнэлгээ хийх аргачлалыг батлах;

38.5.7. таримал ой бүхий газрыг улсын ойн сан бүхий газарт хүлээн авч, цахим системд бүртгэх;

38.5.8. сумын болон сум дундын ойн ангийн үлгэрчилсэн дүрмийг батлах;

38.5.9. ойн баялгийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх болон ашиглалтын бүсийн ойд замын хайгуул хийж, зураг, төсөв боловсруулах, ойн төв зам барьж байгуулах ажлыг зохион байгуулах;

38.5.10. хуульд заасан бусад бүрэн эрх.

38.6. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ холбогдох төрийн байгууллага, орон нутгийн байгууллага, мэргэжлийн холбоотой хамтран ажиллана.

39 дүгээр зүйл. Сумын болон сум дундын ойн ангийн чиг үүрэг

39.1. Сумын болон сум дундын ойн анги нь өөрийн хариуцсан ойн менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулах, зохицуулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих анхан шатны төрийн байгууллага байна.

39.2. Сумын болон сум дундын ойн анги дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

39.2.1. ой хамгаалах, эргүүл, хяналтын үйл ажиллагаа явуулах;

39.2.2. ойжуулалт, нөхөн сэргээлт, арчилгаа, цэвэрлэгээ хийх ажлыг зохион байгуулах;

39.2.3. бэлтгэх модны нөөцийн хэмжээг жил бүр гаргаж, хуваарилах, мод бэлтгэлийн талбайг тусгаарлах, тэмдэгжүүлэх;

39.2.4. ойн дагалт баялгийн ашиглалтын байдалд хяналт хэрэгжүүлэх;

39.2.5. ойн баялгийн нөөц, ашиглалт, доройтол, эрсдэлийн мэдээллийн ойн цахим системд оруулах, шинэчлэх;

39.2.6. ойн дагалт баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах эрх олгох;

39.2.7. агро-ойн аж ахуй болон мод, сөөг тариалах арга хэмжээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

39.3. Сумын болон сум дундын ойн анги нь ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжлийн удирдлага дор ажиллаж, сумын Засаг даргатай хамтран ажиллана.

40 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

40.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

40.1.1. ойн менежментийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн хөгжлийн болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

40.1.2. ой, хээрийн түймэр, байгалийн гамшгийн үед салбар дундын зохион байгуулалтыг хангах;

40.1.3. ой, хээрийн түймрийг унтраах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, шаардагдах зардлыг шийдвэрлэх, хохирол тооцох ажлыг хэсэг томилж ажиллуулах, хохирлыг нэхэмжлэх;

40.1.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

41 дүгээр зүйл. Сумын Засаг даргын бүрэн эрх

41.1. Сумын Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

41.1.1. сумын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотой зохион байгуулах;

41.1.2. ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, шуурхай арга хэмжээ авах;

41.1.3. иргэдийн ахуйн хэрэгцээ, уламжлалт хэрэглээг хуульд нийцүүлэн зохицуулах;

41.1.4. хууль бус ашиглалт, зөрчлийн талаар холбогдох байгууллагад мэдээлэх, хамтран ажиллах;

41.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

42 дугаар зүйл. Салбар дундын уялдаа, хамтын ажиллагаа

42.1. Ойн баялгийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах, ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулах, хууль бус ашиглалттай тэмцэхэд төрийн болон орон нутгийн холбогдох байгууллага өөрийн бүрэн эрхийн хүрээнд хамтран ажиллана.

42.2. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, түймрийн үед шуурхай хариу арга хэмжээ авах чиг үүргийн хүрээнд онцгой байдлын байгууллагатай хамтран ажиллана.

42.3. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ойн сан бүхий газар, ойн баялгийн нөөцтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиг үүргийн хүрээнд цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

42.4. Аймаг, нийслэл, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг шийдвэрлэнэ.

42.5. Төрийн болон орон нутгийн байгууллага нь ойн баялгийн нөөц, ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлттэй холбоотой мэдээллийг энэ хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу харилцан солилцоно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ОЙГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХЭД ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОРОЛЦОО

43 дугаар зүйл. Ойн мэргэжлийн үйл ажиллагаа, түүний төрөл

43.1. Ойн мэргэжлийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

43.1.1. ойн тооллого, ой зохион байгуулалт хийх; 43.1.2. ойжуулах, ойг нөхөн сэргээх; 43.1.3. ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийх, тэдгээртэй тэмцэх;

43.1.4.ойн төлөв байдлыг сайжруулах; 43.1.5.үйлдвэрлэлийн зориулалтаар мод бэлтгэх; 43.1.6.ойн дагалт баялгийг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх.

43.2. Хуулийн этгээд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөл авна.

43.3. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд дараах нийтлэг шаардлага тавигдана.

43.3.1. мэргэжлийн хүний нөөцтэй байх;

43.3.2. зориулалтын программ хангамж, техник, машин механизм, тоног төхөөрөмж, багаж, хэмжих хэрэгсэлтэй байх;

43.3.3. стандарт шаардлагад нийцсэн агуулахтай байх, эсхүл агуулах түрээслэх гэрээтэй байх,

43.4. Мэргэжлийн үйл ажиллагаа тус бүрд тавигдах тусгай шаардлагыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

43.5. өвшөөрлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлд заасан зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:

43.5.1. үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах болон ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх арга хэмжээний зардлыг жил бүр төсөвтөө тусган хэрэгжүүлэх;

43.5.2. ойн хөнөөлт организмын судалгаа хийх, тэмцэх ажлыг стандартын дагуу ойн экосистемд сөрөг нөлөөгүй байдлаар хэрэгжүүлэх;

43.5.3. жил бүр сумын болон сум дундын ойн ангид мэргэжлийн үйл ажиллагааны талаарх мэдээ, тайлан хүргүүлэх;

43.5.4. ой, хээрийн түймэр унтраахад хүн хүч, тээврийн болон бусад хэрэгслийг гаргаж өгөх;

43.5.5. ойд мод бэлтгэх, судалгаа явуулах, тэмцлийн ажил гүйцэтгэхдээ хууль тогтоомжид заасны дагуу сумын ойн анги, байгаль хамгаалагчид мэдэгдэн ой, хээрийн түймэр гаргахгүй байх баталгаа гаргах;

43.5.6. галын аюултай бодис, шатах, тослох материалыг хэрэглэх, тээвэрлэх, хадгалах журам, горимыг чанд мөрдөж ажиллах;

43.5.7. бүх төрлийн тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох, ажилд гаргахдаа шалгаж байх;

43.5.8. ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах.

44 дүгээр зүйл. Нөхөрлөл

44.1. Нөхөрлөлд ойн сан бүхий газрын тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хариуцуулан хамгаалуулж болно.

44.2. Нөхөрлөл нь дараах үйл ажиллагаа эрхэлж болно:

44.2.1.ой хамгаалах, эргүүл, хяналт, урьдчилан сэргийлэх ажилд оролцох;
44.2.2.босоо хатсан, унанги модыг цэвэрлэх; 44.2.3.ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хянан дүгнэхэд оролцох; 44.2.4.мэдээлэл, экологийн боловсролын сургалтад хамрагдах.

44.3. Нөхөрлөл нь менежментийн төлөвлөгөө, гэрээ, зөвшөөрлийн хүрээнд дараах үүрэг хүлээнэ:

44.3.1.ойн баялгийн нөөцийг хамгаалах; 44.3.2.иргэдийг хариуцан хамгаалж байгаа ойдоо нэвтрүүлэх; 44.3.3.хууль болон гэрээнд заасан төлбөр, үүргийг биелүүлэх.

45 дугаар зүйл. Иргэн, харьяалалгүй хүний эрх, үүрэг

45.1. Монгол Улсын болон гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн түр хугацаагаар ойд чөлөөтэй нэвтрэх, зорчих, амрах эрхтэй.

45.2. Иргэн ойг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ:

45.2.1. ойн тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

45.2.2. ойн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, устгаж сүйтгэсэн зөрчлийн талаар тухайн шатны Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх;

45.2.3. ойг хамгаалах үндэсний уламжлал, ёс заншлыг сахиж, хүүхдэдээ экологийн хүмүүжил олгох;

45.2.4. гал түймрийн улсын хяналтын дүрмийг чанд биелүүлж, түймрийн аюултай үед ил задгай гал түлэхгүй байх, асаасан чүдэнз, татсан тамхины гал, цог, нурмыг бүрэн унтрааж аюулгүй болгох;

45.2.5. гэр, байшин, хураасан өвс, хашаа, саравчны эргэн тойронд хамгаалалтын зурвас татах болон түймэр унтраах байнгын багаж хэрэгсэлтэй байх;

45.2.6. өрх бүр үнс, нурмыг тусгайлан бэлдсэн таглаа бүхий нүх, саванд хийж, түймэр алдахгүй байх нөхцөлийг ханг

45.2.7. ой, хээрийн түймрээс амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөө хамгаалах, түймэр унтраах анхан шатны арга ажиллагааг эзэмшсэн байх, хүүхдээ түймрээс сэрэмжлүүлж сургах;

45.2.8. тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг галын аюулгүйн төхөөрөмжөөр тоноглох, галын аюултай бодис, шатах, тослох материалыг хадгалах горимыг чанд мөрдөх;

45.2.9. хуурай өвс, ургамлын хучаас, тариалангийн талбайн сүрэл, хог ургамал, өтөг бууцыг шатаахгүй байх;

45.2.10. ой, хээрийн түймрийг унтраах ажиллагаанд иргэний журамт үүргийн дагуу оролцох, хувийн эзэмшлийн тээврийн хэрэгслээ ашиглуулах болон ой, хээрийн түймэр илрүүлсэн, түймрийн тухай мэдээ хүлээн авсан бол түүнийг унтраах арга хэмжээг шуурхай авч, холбогдох шатны Засаг дарга, бусад шаардлагатай байгууллагад яаралтай мэдээлэх.

46 дугаар зүйл. Ой бүхий нутгийн иргэдийн эрх

46.1. Ой бүхий нутагт байнга оршин суугч иргэн дараах эрхтэй:

46.1.1. ахуйн хэрэгцээнд мод, ойн дагалт баялгийг хуульд заасан нөхцөл, хэмжээнд ашиглах;

46.1.2. ойн менежментийн төлөвлөгөө боловсруулах, хэлэлцэх, санал өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

46.1.3. ойн ашиглалт, гэрээ, зөвшөөрөл, нөхөн сэргээлт, самрын менежмент, нүүрстөрөгчийн төсөлтэй холбоотой мэдээлэл авах;

46.1.4. хууль бус ашиглалт, түймэр, доройтол, зөрчлийн талаар мэдээлэх;

46.1.5. нөхөрлөл, хоршоо, аж ахуйн нэгжийн хэлбэрээр ойн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцох;

46.1.6. ойн баялгийн нөөцөөс үүсэх эдийн засгийн үр өгөөжөөс хүртэх.

46.2. Энэ зүйлд заасан эрхийг хэрэгжүүлэхдээ тухайн ойн бүсийн ангилал, менежментийн төлөвлөгөө, квот, улирлын зохицуулалтын шаардлагыг мөрдөнө.

46.3. Иргэн нь хууль ёсны оролцоо, мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх, гомдол гаргах, хамгаалуулах эрхтэй байна.

47 дугаар зүйл. Орон нутгийн давуу эрх

47.1. Ой бүхий нутгийн иргэд, нөхөрлөл, малчин өрхийн анхдагч холбоо дараах үйл ажиллагаанд давуу эрхтэйгээр оролцоно:

47.1.1. ойн дагалт баялаг ашиглах; 47.1.2. ойн аялал жуулчлал, экологийн боловсролын үйлчилгээ; 47.1.3. анхан шатны болон нэмүү өртөг шингээсэн боловсруулах үйлдвэрлэл; 47.1.4. нөхөн сэргээлт, ойжуулалт, арчилгаа, хамгаалалтын ажил; 47.1.5. агро-ойн аж ахуй, био-эдийн засгийн жижиг, дунд үйлдвэрлэл.

47.2. Давуу эрх олгохдоо дараах шалгуурыг баримтална:

47.2.1. тухайн нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх; 47.2.2. хууль ёсны бүртгэлтэй байх; 47.2.3. сумын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхтай байх; 47.2.4. байгаль орчны зөрчилгүй, эсхүл зөрчлөө арилгасан байх.

47.3. Орон нутгийн давуу эрх нь зөвхөн ашиглалт, оролцоо, эдийн засгийн боломжид давуу байдал олгоно.

47.4. Ойн баялгийн нөөц ашигласны төлбөр, дагалт баялаг ашиглалтын төлбөр, ойн нүүрстөрөгчийн кредитийн орлого болон хуульд заасан бусад орлогын тодорхой хэсгийг ой хамгаалалт, нөхөн сэргээлт, нөхөрлөлийн үйл ажиллагаанд зарцуулна.

47.5. Орон нутгийн давуу эрх олгох шалгуур, журам, хуваарилалтын мэдээллийг ойн мэдээллийн цахим системд бүртгэж, олон нийтэд ил тод мэдээлнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ОЙН МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ СИСТЕМ, ХЯНАЛТ

48 дугаар зүйл. Ойн мэдээллийн цахим систем

48.1. йн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ойн, ойн баялгийн нөөц, түүний ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, менежменттэй холбоотой мэдээллийг бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, боловсруулах, солилцох, ашиглах зорилгоор улсын хэмжээний ойн мэдээллийн цахим систем ажиллуулна.

48.2. Ойн мэдээллийн цахим систем нь хуульд заасны олон нийтэд ил тод байдал байна.

48.3. Ойн мэдээллийн цахим системд дараах мэдээллээс бүрдэнэ:

48.3.1. ойн бүсийн ангилал, хил зааг, байршил, талбай;

48.3.2. ойн тооллого, ой зохион байгуулалтын мэдээлэл;

48.3.3. ойн менежментийн төлөвлөгөө (улс, аймаг, нийслэл, сум);

48.3.4. зөвшөөрөл, гэрээ, ашиглалтын эрхийн мэдээлэл;

48.3.5. мод, ойн дагалт баялаг, хуш модны самар бэлтгэлийн бүртгэл;

48.3.6. ойн аж ахуйн арга хэмжээний мэдээлэл;

48.3.7. ойн нүүрстөрөгч шингээлт, ялгаралтын бүртгэл, зах зээл, төслийн мэдээлэл;

48.3.8. түймэр, хөнөөлт организм, байгалийн гамшгийн мэдээлэл;

48.3.9. хяналт шалгалт, зөрчил, авсан арга хэмжээний мэдээлэл;

48.3.10. ойн туршилт, судалгааны байнгын болон түр талбайн байршил, арчилгааны мэдээлэл;

48.3.11. нөхөрлөлийн үйл ажиллагаа, гэрээ, тайлан, талбайн мэдээлэл;

48.3.12. төсөл сонгон шалгаруулалтын мэдээлэл, гэрээ, талбайн хил зааг, хүлээх үүрэг, тайлангийн мэдээлэл;

48.3.13. хөрөнгө оруулалтын болон техникийн туслалцааны төсөл, санхүүжилтийн мэдээлэл;

48.3.14. хуульд заасан бусад мэдээлэл.

48.4. Төрийн байгууллага, сумын болон сум дундын ойн анги, ойн баялгийн нөөцийг ашиглагч, төсөл хэрэгжүүлэгч нь холбогдох мэдээллийг үнэн зөв, бүрэн гүйцэт, хугацаанд нь цахим системд оруулах үүрэгтэй.

48.5. Энэ зүйлийн 48.4-т заасан мэдээллийг албажуулж, ойн мэдээллийн цахим системд бүртгүүлснээр тухайн эрхийг хүлээн авах, хэрэгжүүлэх эрх үүснэ.

48.6. Ойн мэдээллийн цахим систем нь газар, байгаль орчин, кадастр, уур амьсгал, статистикийн мэдээллийн системтэй харилцан уялдаатай байна.

48.7. Ойн мэдээллийн цахим системийн мэдээллийн нууцад хамаарахаас бусад хэсгийг хуульд заасан журмын дагуу олон нийтэд нээлттэй, ил тод байршуулна.

48.8. йн мэдээллийн цахим системийг хөгжүүлэх, ажиллуулах, шинэчлэх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

49 дүгээр зүйл. Ойн салбарын хяналт, ил тод байдал

49.1. Байгаль орчны хяналтын улсын байцаагч ойн салбарын улсын хяналт, шалгалтыг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ.

49.2. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ойн менежмент, ашиглалт, нөхөн сэргээлт, ойжуулалт, дагалт баялгийн ашиглалт, гэрээ, зөвшөөрлийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналт-шинжилгээ хийж, нэгдсэн зохицуулалтыг хангана.

49.3. Сумын болон сум дундын ойн анги нь ойн менежментийн төлөвлөгөөнд тусгасан ойн аж ахуйн арга хэмжээ, түүний хэрэгжилттэй холбоотой мэдээллийг бүрдүүлж, ойн мэдээллийн цахим системд оруулна.

49.4. Зөвшөөрөл, гэрээ, тайлан, ашиглалтын үйл ажиллагааг ойн мэдээллийн цахим системд бүртгэснээр хүчин төгөлдөрт тооцно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

САНХҮҮЖИЛТ, САН, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

50 дугаар зүйл. Санхүүжилтийн эх үүсвэр

50.1. Ойн аж ахуйн арга хэмжээний зардлыг техник эдийн засгийн үндэслэл, төсвийн тооцооллыг үндэслэн төсвөөс санхүүжүүлнэ.

50.2. Ойн аж ахуйн арга хэмжээний дараах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

50.2.1. ойн тооллого, ой зохион байгуулалтын судалгаа хийх зардал;

50.2.2. ой, хээрийн түймрийн тархалтын голомт хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд түүнтэй тэмцэх, хор уршгийг арилгахтай холбогдсон зардал;

50.2.3. ойн хөнөөлт организмын судалгаа хийх зардал;

50.2.4. хөнөөлт организмын тархалтын голомт хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд түүнтэй тэмцэх, хор уршгийг арилгахтай холбогдсон зардал;

50.2.5. улсын ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөхөн сэргээлт, ойжуулалт, ой хамгааллын зардал;

50.2.6. ойн мэдээллийн цахим санг бүрдүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах зардал;

50.2.7. засгийн газраас санхүүжүүлэх шаардлагатай гэж үзсэн ойн аж ахуйн арга хэмжээний бусад зардал.

50.3. Ойн аж ахуйн арга хэмжээний дараах зардлыг аймаг, нийслэл, сумын төсвөөс санхүүжүүлнэ:

50.3.1. ойн хөнөөлт организмаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал;

50.3.2. хөнөөлт организмын тархалтын голомт тухайн аймгийн хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд түүнтэй тэмцэх, хор уршгийг арилгахтай холбогдсон зардал;

50.3.3. ой, хээрийн түймрийн тархалтын голомт тухайн аймгийн хэд хэдэн сумын нутаг дэвсгэрийг хамарсан тохиолдолд түүнтэй тэмцэх, хор уршгийг арилгахтай холбогдсон зардал;

50.3.4. аймаг, нийслэл, сумын ойн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ойн нөхөн сэргээлт, ойжуулалт, ой хамгааллын зардал;

50.3.5. ойн зам гаргах, түүний зураг төсөв боловсруулах зардал;

50.3.6. аймаг, нийслэл, сумын Засаг даргаас санхүүжүүлэх шаардлагатай гэж үзсэн ойн аж ахуйн арга хэмжээний бусад зардал.

50.4. Ойн аж ахуйн арга хэмжээний дараах зардлыг аймаг, нийслэл, сумын төсвөөс Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.4-т заасан ойн баялгийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос санхүүжүүлнэ:

50.4.1. аймаг, нийслэл, сумын ойн менежментийн төлөвлөгөөнд туссан тухайн жилийн ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;

50.4.2. сум, сум дундын ойн ангийн албан хаагчдын цалин, үйл ажиллагааны урсгал зардал;

50.4.3. ойн модны нөөцийг ашиглах талбайн зураглал гаргах, ашиглалтад хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлэх зардал;

50.4.4. ойн дагалт баялгийн нөөц, төлөв байдлын жил бүрийн судалгаа хийлгэх зардал;

50.4.5. тухайн сумын нутаг дэвсгэрт гарсан хөнөөлт организмын тархалтын голомттой тэмцэх, хор уршгийг арилгахтай холбогдсон зардал;

50.4.6. тухайн сумын нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн түймрийг унтраах, хор уршгийг арилгахтай холбогдсон зардал;

50.4.7. аймаг, нийслэл, сумын Засаг даргаас санхүүжүүлэх шаардлагатай гэж үзсэн ойн аж ахуйн арга хэмжээний бусад зардал.

50.5. Ойн аж ахуйн арга хэмжээг бусад эх үүсвэрийн хөрөнгөөр санхүүжүүлж болно.

51 дүгээр зүйл. Ойжуулалтын сан

51.1. Ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх, мониторинг хийх, ойн мэдээллийн цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангах, салбарын тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор ойжуулалтын сантай байна.

51.2. Ойжуулалтын санг энэ хуульд заасан зориулалтаар төвлөрүүлж, зарцуулна.

51.3. Ойжуулалтын сангийн зохион байгуулалт, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар батална.

51.4. Аймаг, нийслэл, сум болон сум дундын ойн анги, нөхөрлөл, хот айл болон бусад эрх бүхий этгээд нь ойжуулалтын сангаас санхүүжилт авах хүсэлтийг ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

51.5. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ойн менежментийн төлөвлөгөө, ойн баялгийн нөөцийн үнэлгээ, эрсдэлийн түвшинд үндэслэн санхүүжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ойжуулалтын сангийн хөрөнгийг захиран зарцуулна.

51.6. Ойжуулалтын сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна:

51.6.1. ой хамгаалалт, ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулах;
51.6.2. нөхөн сэргээлт, ойжуулалт, арчилгаа; 51.6.3. ойн тооллого, ой зохион байгуулалт; 51.6.4. нөхөрлөл, орон нутгийн иргэдийн чадавх бэхжүүлэх; 51.6.5. хамгаалалтын бүсийн ой, тусгай зориулалтын ой, хушин ойд хэрэгжүүлэх тусгай арга хэмжээ; 51.6.6. хуульд заасан бусад.

51.7. Ойжуулалтын сангийн хөрөнгийг энэ хуулийн 51.6-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

51.8. Ойжуулалтын сангийн үйл ажиллагаанд төсвийн хяналт, төрийн аудит болон хуульд заасан бусад хяналт хэрэгжинэ.

52 дугаар зүйл. Ойжуулалтын сангийн эх үүсвэр

52.1. Ойжуулалтын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

52.1.1. ойн баялгийн нөөц ашигласны төлбөр;

52.1.2. олон улсын хөтөлбөр, төсөл, буцалтгүй тусламж, хандив;

52.1.3. экосистемийн үйлчилгээний орлого;

52.1.4. ойн баялагт учирсан хохирлын нөхөн төлбөр;

52.1.5. хуульд нийцсэн бусад эх үүсвэр.

52.2. Ойжуулалтын сантай холбогдсон нийтлэг харилцааг Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн хуулиар зохицуулна.

53 дугаар зүйл. Нүүрстөрөгчийн сан

53.1. Ойн нүүрстөрөгчийн шингээлт, ялгаралтай холбоотой төсөл, бүртгэл, баталгаажуулалт, зах зээлийн оролцоог дэмжих зорилгоор ойн нүүрстөрөгчийн худалдааны орлогоос бүрдсэн ойн нүүрстөрөгчийн сантай байж болно.

53.2. Сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, бүртгэл хөтлөх, тайлагнах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.

53.3. Сангийн хөрөнгийг захиран зарцуулах үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

53.4. Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нүүрстөрөгчийн сангийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

53.4.1. нүүрстөрөгчийн төсөл, бүртгэл, баталгаажуулалтын техникийн санал боловсруулах;

53.4.2. төсөл, арга хэмжээний хэрэгжилт, мониторинг, мэдээллийг нэгтгэх;

53.4.3. орлогын хуваарилалтын шалгуур, тооцоог боловсруулах.

53.5. Нүүрстөрөгчийн сангийн хөрөнгийг дараах зориулалтаар зарцуулна:

53.5.1. нүүрстөрөгчийн тооцоо, бүртгэл, тайлагнал, баталгаажуулалт;

53.5.2. нүүрстөрөгчийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;

53.5.3. орон нутгийн оролцогчдын чадавх бэхжүүлэх;

53.5.4. орлогын хуваарилалт;

53.5.5. эрсдэлийн нөөц, хамгаалалтын тогтолцоо;

53.5.6. хуульд заасан бусад.

54 дүгээр зүйл. Ойн хөрөнгө оруулалт, хувийн хэвшлийн оролцоо

54.1. Ойн салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн татна.

54.2. Ойн салбарын хөрөнгө оруулалт нь хуульд заасан шаардлагыг хангасан байна.

54.3. Дараах чиглэлд тэргүүн ээлжид хөрөнгө оруулалтыг дэмжинэ:

54.3.1. ойжуулалт, нөхөн сэргээлт, үржүүлэг; 54.3.2. нүүрстөрөгчийн төсөл, экосистемийн үйлчилгээ; 54.3.3. био-эдийн засаг, инновац; 54.3.4. нэмүү өртөг шингээсэн мод боловсруулах үйлдвэрлэл; 54.3.5. ойн аялал жуулчлал; 54.3.6. дагалт баялгийн боловсруулалт, логистик, маркетинг; 54.3.7. мэдээллийн систем, мониторинг, мэргэжлийн үйлчилгээ.

54.4. Хувийн хэвшил, нөхөрлөл, малчин өрхийн анхдагч холбоо, мэргэжлийн холбоо, судалгааны байгууллага нь хамтарсан төсөл, түншлэлийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийж болно.

АРАВ ДУГААР БҮЛЭГ

БУСАД

55 дугаар зүйл. Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалт

55.1. Ойн менежментийн төлөвлөгөөнд тусгасан мод бэлтгэл, боловсруулах үйлдвэрлэлийн үйл явц нь Монгол Улсын, эсхүл олон улсын ойн тогтвортой менежментийн стандартыг хангаж байгааг нотлох үйл явцыг ойн тогтвортой менежментийн баталгаажуулалт гэнэ.

55.2. Монгол Улсын ойн тогтвортой менежментийн үндэсний стандартыг ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

55.3. Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хоёр болон олон талт олон улсын гэрээнд ойн тогтвортой менежментийн

баталгаажуулалтын дүнг харилцан хүлээн зөвшөөрөх заалтыг тусгах асуудлыг хариуцна.

55.4. Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалтыг мод бэлтгэл, боловсруулах үйлдвэрлэл эрхэлж байгаа хуулийн этгээд хийлгэж болно.

55.5. Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалтыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу итгэмжлэгдсэн, эсхүл бүртгүүлсэн баталгаажуулалтын байгууллага /цаашид "баталгаажуулалтын байгууллага" гэх/ гүйцэтгэнэ.

55.6. Ойн мэдээллийн цахим системд бүртгэлгүй баталгаажуулалтын байгууллага ойн тогтвортой менежментийн баталгаажуулалт хийхийг хориглоно.

55.7. Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалт хийлгэх хүсэлтэй энэ хуулийн этгээд ойн мэдээллийн цахим системд хэрэглэгчээр бүртгүүлэх хүсэлт илгээж, хэрэглэгчээр бүртгүүлнэ.

55.8. Ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас шаардлага хангасан хуулийн этгээдийг хэрэглэгчээр бүртгэж, мэдээллийн санд хандах эрх олгоно.

55.9. Хуулийн этгээд нь ойн мэдээллийн цахим системд бүртгэлтэй баталгаажуулалтын байгууллагаас сонгож, өөрийн үйл ажиллагааг баталгаажуулах хүсэлт, холбогдох бусад мэдээллийг илгээнэ.

55.10. Хүсэлт хүлээн авсан баталгаажуулалтын байгууллага баталгаажуулалтыг хийж, цахим гэрчлэх тэмдэг олгоно.

55.11. Ойн тогтвортой менежментийн баталгаажуулалтын гэрчилгээ, гэрчлэх тэмдэг /лого/-ний загварыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

55.12. Баталгаажуулалтын байгууллага нь баталгаажуулалт хийлгэсэн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлага тооцох, баталгаажуулалтыг хүчингүй болгох арга хэмжээ авна.

56 дугаар зүйл. Ойд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх

56.1. Ойд хохирол учруулсан этгээд уг хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

56.2. Энэ хуулийн 56.1-д заасан хохирол болон ойг нөхөн сэргээхэд шаардагдах зардлын нөхөн төлбөрийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу байгаль орчны хяналтын улсын байцаагч ногдуулж, холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлнэ.

56.3. Ойд учруулсан нөхөн төлбөрийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэмжээгээр тогтооно.

56.4. Ойн санд учирсан хохирлын талаарх мэдээ, тайланг ойн мэдээллийн системд тухай бүр оруулна.

56.5. Ойд учруулсан хохирлын нөхөн төлөлтийн байдалд ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хагас, бүтэн жил тутам хяналт тавьж, хэрэгжилтийг хангах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

57 дугаар зүйл. Хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлага

57.1. Ойн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд үйлдэл, эс үйлдэхүйн шинж, учруулсан хор уршиг, нийгмийн аюул, гэм буруугийн хэмжээнээс хамааран эрүүгийн, зөрчлийн болон иргэний хариуцлага хүлээлгэнэ.

57.2. Дараах үйлдэл, эс үйлдэхүйг ойн тухай хууль тогтоомж зөрчсөнд тооцно:

57.2.1. зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах;

57.2.2. батлагдсан менежментийн төлөвлөгөө, зөвшөөрөл, гэрээг зөрчих;

57.2.3. нөхөн сэргээлт, ойжуулалтын үүргээ биелүүлэхгүй байх;

57.2.4. ойн мэдээллийн цахим системд худал мэдээлэл оруулах, мэдээлэл нуух;

57.2.5. хушин ой болон бусад эмзэг ойн экосистемд хохирол учруулах;

57.2.6. ойн бүсийн ангилал, дэглэм зөрчих;

57.2.7. зөвшөөрөгдсөн хэмжээнээс давуулан ашиглалт явуулах;

57.2.8. ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчний эрсдэлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулах;

57.2.9. үнэлгээ, төлөвлөгөө, тайлан, тооцооллыг санаатайгаар буруу гаргасан, нуусан, хуурамчаар үйлдсэн.

57.3. Энэ зүйлийн 57.2-т заасан зөрчил нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

57.4. Эрүүгийн болон зөрчлийн хариуцлага хүлээсэн нь тухайн этгээдийг иргэний хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

57.5. Төрийн албан хаагч энэ хуульд заасан чиг үүргээ зөрчсөн бол Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.